



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/370

Ховд

Хөтөлбөрийг хэрэгжүүлж хөрөнгө  
зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 56 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд 132,000,000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах 132,000,000 (нэг зуун гучин хоёр сая) төгрөгийг 2025 оны аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээний зардлаас тооцож олгохыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батсайхан), Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Анхбаяр) нарт зөвшөөрсүгэй.

3. Хөтөлбөрийн санхүүжилтийг хууль тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулахыг Мал эмнэлгийн газрын дарга (Д.Батцэнгэл)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Баасанхүү)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА

8400001 1129

Zah A/370 Kh

Засаг даргын 2025 оны 05 дугаар  
сарын 13-ны өдрийн А/370 дугаар  
захирамжийн хавсралт



МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ХӨТӨЛБӨРТ 2025 ОНД ОРОН  
НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХЭЭР ТУСГАСАН АРГА ХЭМЖЭЭ, ЗАРДАЛ

| №    | Санхүүжилтийн нэр,<br>зориулалт                                                                     | Тусгасан төсөв<br>(сая төгрөг) |
|------|-----------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------|
| 1    | Сумдын Мал эмнэлгийн газар,<br>тасгийн албан хаагчдын тавилга, тоног төхөөрөмж                      | 50,000,000                     |
| 2    | Халдвар хамгаалал, халдваргүйжүүлэлтийн зардал                                                      | 5,000,000                      |
| 3    | Лабораторийн шинжилгээ, МЭАЦ, эмийн үлдэгдэл,<br>бичил биетний тэсвэржилтийн шинжилгээ              | 12,000,000                     |
| 4    | Сургалт, мэдээлэл сурталчилгаа                                                                      | 5,000,000                      |
| 5    | Мөст сумын нэг сум, нэг мал эмнэлэгийн үйлчилгээг<br>нэвтрүүлж, байрны засвар үйлчилгээг сайжруулах | 51,500,000                     |
| 6    | Мөст сум мал эмнэлгийн халаалтын систем, өргөх<br>насос, кабель, жанам засвар                       | 8,500,000                      |
| Нийт |                                                                                                     | 132,000,000                    |

-oOo-